



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 10/А1560249/ӨБА-2025/028/ТА-СТА-ТМЗ Арвайхээр сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 84,536.0 мянган төгрөгийн 27 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын даргын гаргасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын дарга 3.Цэцэгмаа, нягтлан бодогч Г.Оюунмандах-нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Байгуулалтын нэр: Хужирт сумын ЗДТГ
Тайлант хугацаа: 2024 он

ААБ 6.6: АУДИТААР ИЛГҮҮСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТЭЛ

Нөхөрлөл

№	АГАДУТ-ийн дэд анги	Алдаа, зөрчилний товч утга	Мөнгөн дүн / төгрөгөөр	Материал-лаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчилний ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын сандал, тайлбар	Аудитын байгууллагаас өссөн хэрэг	Гаргасан шийдэл
						стандартын залалт	хууль тогтоомжийн залалт					
Санхүүгийн аудитын асуудал												
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
2	Ажил Гүйцээний анги	Нийт хөрөнгө	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийхдээ хөрөнгийн ангилал тус бүрээр тооллогын бүртгэлийг нэгтгэн гаргасан боловч тооцоо бодоогүй, тооллогын комисс нь тооллого хийсэн тухай илтгэх хуудас бичсэн нь зөрүүтэй, байгуулалтын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.	түгш	үүр	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн тооллог	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4/1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шидвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, худалдан аваартай тооцоо хийж, үндэглэлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. СТА-ын "Оршин байх" "Иж бүрэн байх" батламж мэдэглэлийг хангахгүй байна.	Нягтлан бодох бүртгэл тайлангатай холбоотой	Зөвлөмж хүргүүлэх	Зөрчлийг арилгаж, хэрэг ирүүлнэ	Хясаа бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооллогын тооцоо бодсон актыг үндэж, өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж байх.	Зөвлөмж хүргүүлэх
3	Ажил Гүйцээний анги	Бараа материал	Няравын тайлангийн шатахуун зарцуулалтын шаардах хуудас дээр байгуулалтын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулаагүй байна.	түгш	үүр	УСНББОУС-17 Бараа материал	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үндэсэн, зөвшөөрсөн буюу шалтгаан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. СТА-ын "Иж бүрэн байх" батламж мэдэглэлийг хангахгүй байна.	Нягтлан бодох бүртгэл тайлангатай холбоотой	Зөвлөмж хүргүүлэх	Зөрчлийг арилгаж, хэрэг ирүүлнэ	Анхан шатны баримт бүртгэлийг сайжруулж, хууль, журмыг баримтгаж ажлалгах	Зөвлөмж хүргүүлэх
Нийслэлийн аудитын асуудал												
		Дүн										
	Ажил Гүйцээний анги	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулах тухай 84,536.0 мянган төгрөгийн 27 шидвэрийг байршуулаагүй байна.	84,536,000.00	үүр	үүр		Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүссэн аливаа шидвэр" гэж заасантай нийцээгүй байна.	Хууль тогтоомжийн биелэлтэй холбоотой	Албан шаардлага өгөх	Зөрчлийг давтан гаргахгүй	Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх	Албан шаардлага өгөх
6	Ажил Гүйцээний анги	Нийт зардал	Төсвийн хөрөнгөөр 990.0 мянган төгрөгийн мөнгөн арга худалдан авч худалдтал үзүүлсэн.	990,000.00	үүр	үүр	Төрийн хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлтгэж, дараагийн жил худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	Албан шаардлага өгөх	Зөрчлийг давтан гаргахгүй	Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх	Албан шаардлага өгөх
		Дүн	84,536,000.00									
Ташаагч зөрчилсөргөн.												

Тайлцаж зөвшөөрсөн:
Хужирт сумын ЗДТГ-ын дарга
Хужирт сумын ЗДТГ-ын нягтлан бодогч

3 Цэцэгмаа
Г.Оюунмандрах

9045562 СБТ-24-68 10724010134